

НАРАН СУМЫН 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2023.09.25

№ 12

Хонгор

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 52 иргэн хамрагдаж, мэргэжилтнүүд ажлын чиглэлээрээ хууль эрх зүйн мэдээлэл өгч, гарын авлага тарааж ажиллалаа. Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бараа бүтээгдэхүүн сурталчлах үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. 6 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр оролцсон.



Суманд нохой устгалын ажлыг БОХ-ын улсын байцаагч, Багийн Засаг дарга нар зохион байгуулж 25 нохой устгалаа.





Баяр наадмын комиссууд баяр наадмын хөтөлбөр, санамж зөвлөмжийг ард иргэдэд хүргэж, зохион байгуулж ажиллалаа.

[illegible]

Тугалар төрийн 2232, Их Монгол Улсын
817, Үндэний эрх чөлөө, тусгаар тогтнолоо
сэргээх нэгддүгэний 112, Ардын хувьсгалын
102 жилийн ойн баяр нагам

[illegible]

БАЯР НААДМЫН МОРИНЫ
КОМИСС

ЭРХЭМ ХҮНДЭТ УЯАЧИД, НААДАМЧДЫН АНХААРАЛ:

АНХЛААРЛЫН

Хурдал
Бүртгэлтийн 2023.07-08-ны өдөр 14:00 - 18:00 цаг хүртэл, 2023.07.09-ны 9:00-21:00 цаг хүртэл ЗДТГ-ын байр "Иргэний танхим" д-д.

БҮРТГЭЛЭЭХЭЭР ЦАХИРДЭЭ:

- ✓ Ялалт та өөрийн ЦАХИХ ҮНЭМЛЭХЭЙТЭЭЭР ирэх
- ✓ 8-аас дээш насны УНААНА хүүхдийнхээ ОРШИЛЫН ТАЛБАРТЭЭЭР заавал ирэх
- ✓ Өөрийн үүдээ бүт төрөл насны зогсон гэрээгээр уншуул байгаа хүүхдийнхээ эцэг эцэгт ГЭРЭЭЗ ҮЛЭГЛЭГ, 9ӨШӨӨӨӨӨӨ авх туг тус тус хэвт үлэх
- ✓ Эзүүл мөнгөний цаалт хуулиар хамруулсан гэсэн бичиг авах

Урьдчилан хүүхдийн заавал ГЭРЭЭНИЙН ТАЛБАРТЭЭР даатгуулсны баримт авч ирэх. УНААНА хүүхдээ бүрт карт олгох туг заавал

жиш: 10-ны өдөр УРЛАДНАН ХҮҮХДЭД

Бүртгэлтийн БҮРТГЭЛТ ХИЙХГЭЙ БОЛХОО АНХЛААРЛЫН

НАРАН СУМЫН ХАМТАРСАН БАГ

АЯЛАЛ, ЗУГААЛГА, АМРАЛТЫН ӨДРИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨМЖ

[illegible]

Сумын баяр наадмын хурдан морьдын бүртгэл 7-р сарын 09,10-ний өдрийн 09-18 цаг хүртэл уяач болон уралдаанч хүүхдийн цахим бүртгэл хийж, Цахим бүртгэлд хамрагдсан тохиолдолд морины мандат олгож ажиллаа.



Хүүхэд хөгжил хамгааллын жил, Наран сумын залуучуудын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулсан “Хамтдаа хөгжье” волейболлын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.




Алтан овооны Их тахилга 110 ойн баярын бэлтгэл ажлыг хангаж, сумын ЗДТГ болон албан байгууллагууд, албан хаагчид идэвхитэй оролцлоо. Мөн хандивын аяны суманд зохион байгуулж сумын ард иргэд хандив өргөлөө.



Дарьганга суманд зохион байгуулагдсан “АЖИЛ ОЛГОГЧ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН”-д Дарьганга, Наран, Онгон, Эрдэнэцагаан сумдын ажил олгогч бизнес эрхлэгчид, ХЭДС- ийн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд оролцлоо. Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн “ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА” зохион байгуулагдлаа. 2023.07.20.



Засаг даргын үйл ажиллагааны зардлаас 7.500.000 төгрөгөөр санхүүжүүлэн Жойфүл фамили ХХКомпаний гүйцэтгэлээр ЕБСургуулийн бүх анги, гал тогоо, дотуур байранд 4-6 шатлалт шүлтүүртэй ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулан ЕБСургуулийн болон дотуур байрны сурагчид цэвэршүүлэн ус уух боломжоор бүрэн хангагдлаа.



Аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Гэр төслийн хүрээнд аймгийн Засаг дарга М.Идэрбат, аймгийн ИТХТөлөөлөгч Ө.Тайвансанаа, сумын Засаг дарга Л.Оч нар
1-р баг Э.Содхүү
2-р баг Б.Адьяа
3-р баг Э.Тайвансанаа нарт 4 ханатай өргөө цагаан гэр гардууллаа.



Өвсний фонд, Гэр байранд нарны зай хураагуураар ажилладаг 360 градус хардаг утаснаас бичлэгээ хянадаг камер 2 ширхэгийг, Тамгын газар 1 болон 2 давхарт 1,1 гадна талд 1 нийт 3 ширхэг тус тус байршуулсан.



Намрын шим-2023 үзэсгэлэн худалдаа Сумын Засаг даргын ивээл дор амжилттай зохион байгуулагдлаа. Оёмол бүтээгдэхүүнээр Б.Янжмаа 1-р байр, Б.Долгоржав 2-р байр, Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүний төрөлд Б.Байгаль 1-р байр, У.Сайхантуяа 2-р байр, Шилдэг малын гаралтай түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүний төрөлд Б.Эрдэнэсүвд 1-р байр, М.Зоригтбаатар 2-р байр, Шилдэг талх нарийн боов, хоол үйлдвэрлэлийн төрөлд Б.Наранчимэг 1-р байр, Я.Жаргалсайхан 2-р байр, Шилмэл малын төрөлд У.Сайнжаргал, Б.Гантулга нар тус тус шалгарсан байна.



Сумын 70-аас дээш насны ахмадуудын гадна гэрэлтүүлэг тавихаар Сүхбаатар Ампер ХХК-иас 2,500,000 төгрөгийн гэрэлтүүлэг болон дагалдах хэрэгслийг худалдан авч 70-аас дээш насны 40 ахмадуудын гадна гэрэлтүүлэг тавигдсан.



Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын хүрээнд хүүхэд багачуудын хөгжмийн сонирхол, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор сумын засаг даргын нөөц хөрөнгөөр соёлын төвд 2.500.000 төгрөгний үнэ бүхий 10 ширхэг мандолин хөгжмийг хүлээлгэн өглөө.



УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧИГ:

2023 оны 3-р улирлын байдлаар албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-3 дугаар улирлын байдлаар дээд газраас нийт 68 албан бичиг ирснээс, хариутай бичиг 14 ирж, 12 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 2 албан бичиг байна.

-Мөн 3 дугаар улирлын байдлаар нийт 9 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 6, Зам тээврийн хөгжлийн сайдын Албан даалгавар 1, Аймгийн Засаг даргын албан даалгавар 1, Аймгийн ГБХЗХГ-ын даргын Тушаал 1 ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2023 оны 3-р улирлын байдлаар;

1.Сумын Засаг даргын А-Захирамж - 27

2.Сумын Засаг даргын Б-Захирамж – 5

3. Албан даалгавар –

4.Засаг даргын албан бичиг -9

5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 4

6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 5

7.ЗДТГ-ын даргын албан бичиг -11

Нийт 12 албан бичгийг имэйл, цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР.

2023 оны төсөвт тодотголийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн 2023 оны 7 сарын 31-ний 01 тоот тогтоолоор батлуулсан.

2024-2025 оны төсвийн төсөөллөлийг аймгийн төрийн санд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Төсвийн төслийг Fiscal праграммд шивж оруулж төсвийн 8 сарын бааз татаж аймгийн төрийн санд цахимаар хүргэсэн.

8 сарын 13-нд сангийн яамнаас Тогтвортой амжиргаа төслийн баг суманд ирж 2021,2022 оны Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, 2023 оны иргэдийн санал авсан байдал ажлын хэсгийн эрэмбэлэлтэнд үнэлгээ хийсэн.

3 дугаар улиралын байдлаар

- аймгаас санхүүгийн дэмжлэг -559,486.9 мян төг
- засгийн газрын дотоод шилжүүлэг – 838,260.2 мян төг олгоод байна.

ОНХСангаар тоглоомын талбай, өлзийтбулаг тохижилт, гэрэлтүүлэгийн зураг төсвийн ажлыг 21 сая төгрөгөөр хийх гэрээ байгуулан гэрээний дагуу зураг хийгдсэн. 04 шугамын өргөтгөлийн ажлын тендэрийг зарласан боловч компани оролцоогүй.

Татварын нийт орлого 3 дугаар улиралын байдлаар 121,969.8 мян төгрөг гүйцэтгэл 62 хувьтай байна.

Шилэн дансны мэдээллийг улирал сараар мэдээлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 9 иргэний 2563000 төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн.

Шинэ ажлын байр -10, Ажил зуучлалаар -2 ejob программд бүртгэсэн.

21 иргэнд цаасаар профайлинг хийсэн цалин хөлстэй ажиллагч 9 иргэнийг ejob цахим системд шивсэн.

2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 5 өрхөд мал хүлээлцлээ.


1-р багийн иргэн О.Нармандахад -91, Э.Батрагчаа-81, Т.Болдбаатар -72

П.Дэмбэрэлсумъяа -85, Б.Энхбатад 82 толгой малыг хүлээлцлээ.



ХБИ-ий няравын сургалт, стартап, төсөл хөтөлбөрийн зарыг хүргэн 8 иргэнд мэдээлэл өгч ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр: ХАБЭА-н сарын аяны хүрээнд албан байгууллагуудад хяналт хийсэн үүний дагуу ерөнхий боловсролын сургуульд албан бичиг хүргүүлж ажиллаа.



Нийгмийн халамжийн чиглэлээр: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 4 удаа хийж асаргаа сунгуулах 2, шинээр асаргаа тогтоолгох 1, асран хамгаалагч солих -2, байгууллагын харъяалалгүй ахмадын нэрсийг хэлэлцсэн.

Байгууллагын харъяалалгүй ахмад настаны нэрсийг 2023.09.15-нд амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн 140 ахмадын нэрсийг халамж цахим системд шивсэн 1 ахмад нас хүрээгүй шивэлт хийгдээгүй.

Ахмадын баярыг угтан баярыг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамж гарган 5 төсөвт байгууллагад хүргүүлсэн.

"НЭГ ӨРХӨД -НЭГ ДҮРЭМТ ХУВЦАС" аяны хүрээнд зорилтот 13 өрхийн хүүхдүүдээс дүрэмт хувцасгүй, хичээллийн хэрэглэлээ авч чадахгүй хүүхдийн судалгааг гарган шинэ хичээлийн нээлтийн үйл ажиллагаан дээр цэцэрлэг сургуулийн насны 2 хүүхдэд дүрэмт хувцас, цэнхэр цамц, цэцэрлэгийн насны 1 хүүхдэд хичээллийн хэрэгсэлийг олголоо.



Түлээний хөнгөлөлт авах 25 иргэний үйлчилгээг халамж цахим системд шивэлт хийсэн.

Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 8 дугаар сарын 31-ны байдлаар

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	238	69388845
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	251	33455341
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	114	20340416
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	164	13400000
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	77	2740645
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	112	4015328
7	Алдарт эхийн одонтой эхэд	144	18600000
8	Хүүхэд асарсны тэтгэмжинд	696	34085317

МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Мал эмнэлгийн 100-н жил болохтой холбоотойгоор хандивын 5 хонийг малчдаас авч аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.



Мөн хонины цэцэг, бруцеллёзын тарилгыг татан авч Сумын Засаг даргын захирамжаар тарилгын ажлыг зохион байгуулж, мэдээг өдөр бүр мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.



9 сарын 15,16-ны өдрүүдэд хээлтүүлэгч малаас бруцеллёзын тандалт цус авах ажил хийгдсэн. Нийт 476 хуц ухнаас дээж авч ажилласан. Шинжилгээнд хамрагдсан нийт хээлтүүлэгчээс 5-д нь бруцеллёзийн халдвар илэрсэн. Үүнийг хариуцсан малчин болон хөдөө аж ахуйн тасгийн үржил хариуцсан мэргэжилтэн мэдэгдсэн.



ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Наран сумын улсын бүртгэгч С.Энхбаатар би Монгол Улсын Үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хувь хүний нууцийн тухай хууль, Албаны нууцийн тухай хууль зэрэг бусад хууль тоогтоом заавар, УБЕГ даргын тушаал зэргийг өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэж ажиллаж байна.


- Иргэний болон гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр доорхи үйлчилгээг хийж гүйцэтгэв. Үүнд :
 - Төрсний бүртгэл – 1
 - Гэрлэлтийн бүртгэл - 0
 - Нас барсан - 0
- *Иргэний цахим үнэмлэх олголт:*
 - Иргэний үнэмлэх захиалга ИУБ-31 – 1 иргэн
 - Иргэний үнэмлэх олголтын бүртгэл – 25 иргэн
 - Иргэний үнэмлэх лавлагаа иргэнд -6
 - Иргэний үнэмлэхний лавлагаа олголт албан хэрэгцээнд – 0
 - Гэрлэлт бүртгэлгүй лавлагаа албан хэрэгцээнд -0
 - Гэрлэсний лавлагаа албан хэрэгцээнд – 0
 - Төрсний лавлагаа албан хэрэгцээнд -0
 - Төрсний бүртгэлийн лавлагаа иргэнд-1
 - Оршин суугаа хаягын лавлагаа иргэнд -3
- Иргэний Шилжилт хөдөлгөөн
 - Аймаг нийслэлээс шилжиж ирсэн - 0
 - Сум хооронд шилжиж ирсэн насанд хүрсэн – 3 хүүхэд
 - Баг хооронд ирсэн насанд хүрсэн -0
 - Тоон гарын үсэг олгосон байдал-12 иргэнд олгосон байна.

Иргэний бүртгэлийг холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэж ИУБ хаатар маягтуудыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажилласан.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2023.08.21-ны өдөр Асгат суманд зохион байгуулагдаж буй БДБХДН-ийн "Сургуулийн сайхан эхлэл - Сургуулийн сайхан амьдрал" төслийн сургалтын Алслагдсан хөдөөгийн малчдын цэцэрлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхэдтэй ажиллах Бага боловсролын багш, СӨБ-ын багш нарын хамтран гаргасан үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсрууллаа. Мөн Дотуур байрны багш нарын үлгэрчилсэн төлөвлөгөөг нэгтгэж Дотуур байрны багш О.Ганболд танилцууллаа.



2023-2024 оны хичээлийн жилийн БОЛОВСРОЛЫН ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА-БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ багш, удирдах ажилтны зөвлөгөөнд сургалтын менежер, нийгмийн ажилтан нар хамрагдлаа. 2023.08.31



2023-2024 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 1-р ангид элсэн орох суралцагчдаа хүлээн авлаа. Мөн багш нарт хичээлийн үйлдвэрлэлийн зардлаас сургалтын хэрэглэгдэхүүний багцыг олгож, хамтран ажилласан. Аймгийн засаг дарга, сумын засаг даргын тамгын газар, сум орон нутгийн удирдлагуудын дэмжлэгээр шинэ хичээлийн жилийн босгон дээр багш нар маань сүүлийн үеийн өндөр үзүүлэлттэй компьютерийг гардан авсан.



2023-2024 оны хичээлийн жилийн эхний өдөр “Эх хэлний өдөр зарлах тухай” зарлигийн 4-т заасны дагуу 9-р сарын 1-ний өдрийн 1-р цагийг “Эх хэлний үүсэл хөгжил” сэдвээр нийт 11 бүлэгт зохион байгуулж, анги удирдсан багш нар удирдан чиглүүлж ажиллалаа. Энэ хичээлийн хүрээнд түүх нийгмийн ухаан болон монгол хэл уран зохиолын багш нар хамтран цахим мэдээлэл бэлтгэн оруулсан ба сурагчдын бүтээл хийлгэж үзэсгэлэн гаргалаа.




2023-2024 оны хичээлийн жилд 11 бүлэгт 278 суралцагч 14 багш, 3 удирдлага 17 ажилтантай сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Энэ хичээлийн жилээс үндэсний хэмжээнд төрийн өмчит бүх ЕБС-ийн V-VI ангид "Pearson English" англи хэлний сургалтын цогц хөтөлбөр, 3,4-р ангид EDUTEN математикийн хөтөлбөр хэрэгжиж эхлэж байгаа тул мэргэжлийн болон АУБ нар танхим болон цахимаар сургалтад хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлэн ажиллаж байна.

Шинэ хичээлийн жилийн анхны хурлыг байгууллагын удирдлагууд зохион байгуулж багш ажилтанд Боловсролын ерөнхий хуулийн холбогдох заалт, цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, цаашид хийх ажлын төлөвлөлтийг гаргаж санал бодлыг нь сонсож ажилласан.



2023.09.11-ны өдөр Нийгмийн ажилтан БШУЯ, БЕГ, ЗГХА-аас хамтран зохион байгуулж буй "After school платформ" дээр хүүхдийн хөгжлийг дэмжсэн шинэлэг сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх сургалтад хамрагдлаа.



2023.09.13-ны өдөр БШУГ-ын зөвлөн туслах баг хөтөлбөрийн дагуу ажиллаж, багш нарын хичээл үйл ажиллагаа, баримт бичиг, сургууль, дотуур байрны хоол үйлвэрлэл, эрүүл ахуйн үйл ажиллагаатай танилцаж заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн эцэг эхчүүдэд Боловсролын ерөнхий хуулийн танилцуулга болон цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж харилцан санал бодлыг нь сонсож ажилласан.




“Номын баярын өдөр”-ийг угтан 5-6 -р ангийн сурагчдад НҮБ-аас алслагдсан орон нутгийн хүүхдүүдэд адал явдалтай, богино өгүүлэгийн илгээсэн номыг Англи, Орос хэлний багш нартай хамтарч “Номын танилцуулга”-ыг зохион байгуулж харилцан суралцагчдын санал бодлыг сонсож ажиллалаа. 2023.09.15



2. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ:

“Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил”-ийн хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны зардлаас 7.500.000 төгрөгөөр санхүүжүүлэн “Жойфүл фамили” гүйцэтгэлээр сургуулийн бүх анги танхим, гал тогоо, дотуур байранд 4-6 шатлалт шүлтүүртэй ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилууллаа.




2023.09.04-ны өдөр дотуур байрны багшийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад 2 иргэн оролцож шалгуур үзүүлэлтийн дагуу Б.Баасанжав тэнцэж ажилд орж Дотуур байрны багшийн хүүхэд хамгааллын “БАТЛАМЖ -ЁС ЗҮЙН ДҮРЭМ - НУУЦЫН ГЭРЭЭНД”- нд гарын үсэг зурлаа. .



2023-2024 оны хичээлийн гадуурх хөгжил, оролцооны төлөвлөгөөг боловсруулах саналыг АУБ-нараас авч сургуулийн хэмжээний болон анги удирдсан багштай хамтран ажиллах НА-тны жилийн төлөвлөгөөг гарган ажилласан. мөн энэ хичээлийн жилийн ангийн суралцагчдын дэлгэрэнгүй болон хүүхэд хамгааллын судалгааг АУБ нараар гаргуулан авч анализ дүгнэлт хийж ажиллаж байна.

АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгт түшиглэн “Багшийн эрүүл мэндийг дэмжих төв” -ийг байгуулсан. Тус төв энэ хичээлийн жилээс цэцэрлэг, сургуулийн эмч нарыг сургаж

хөгжүүлэх, багшийн эрүүл мэндийн чиглэлээр тодорхой үйл ажиллагааг явуулахаар төлөвлөж 9 дүгээр сарын 8-ны өдрийн 14:00 цагт захирал, нийгмийн ажилтан, эмч нарт мэдээлэл сургалтыг зохион байгууллаа.



Сүхбаатар аймгийн ИХ-ын 2023.01.31-ны өдрийн №02 тогтоолоор "ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ ЖИЛ" -ИЙН сарын аяны төлөвлөгөөг 14 шалгуурын дагуу гаргаж, сарын аяны нээлтийг 2023.09.13-ны өдөр хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

Нээлтэд сумын засаг даргын орлогч М.Ганхөлөг болон Сүхбаатар аймгийн БШУГ-ын мэргэжилтнүүд оролцож, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл хийж ажилаллаа.



Сүхбаатар аймгийн ЭМГазрын даргын 2023.09.07 / 478 тоот албан бичиг, Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад 2023-2024 оны хичээлийн жилд баримтлах чиглэл 1.8-д заасны дагуу 6 настай хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.



Номын санч “Номын баяр- 2023 “ угтаж 1 ангийн бяцхан сурагчиддаа “Манжин “ үлгэрээр хүүхэлдэйн жүжигчилсэн тоглолтыг анги удирдсан багштай хамтран зохион байгууллаа.



3. БУСАД АЖ АХУЙН АЖИЛ:

- ✓ 2023.08.24-ны өдөр суралцагчид хуульчилсан дотуур байрны 1,2-р давхарын өрөө тасалгаа, гадна дотно талын цонхыг угааж цэвэрлэгээ үйлчилгээ хийлээ.



- ✓ Сургуулийн гадна талыг пасатыг засан сайжруулах, их засвар хийх ажлыг “Дэвших үүдэн хаалга ХХК” зохион байгуулж ажилласан. Мөн сургуулийн гадна талбайг томосгох, цемент цутгах, явган хүний зам тавих ажлыг багш, ажилчдын хүчээр зохион байгуулж орчиндоо анхаарч ажилласан.



- ✓ Сургууль, дотуур байр, спорт зааланд гэрэлтүүлэг хийх, сургуулийн гадна крилл, монгол бичгийн зэрэгцүүлэн бичсэн гэрлэн хаягийг байршуулах ажлыг хийж гүйцэтгэж сургуулынхаа өнгө үзэмжинд анхаарч ажилласан.



СӨБ-ИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Сургалт үйл ажиллагааны хүрээнд

БШУЯ-аас санаачлан зохион байгуулсан Боловсролын шинэ сэргэлт-Сургуулийн өмнөх боловсрол сэдэвт 3 өдрийн сургалтад эрхлэгч хамрагдаж Боловсролын Ерөнхий хуулийн хэлэлцүүлэг, танилцуулгат оролцлоо.



БШУГ-аас жил бүр зохион байгуулагддаг Багш нарын бага хуралд оролцож аймаг сумын ОНХС-аас санаачлан санхүүжүүлж байгууллагын багш нарын 70%-ийг компьютержуулсан ба манай байгууллагат Dell брендын 3ш компьютерийг гардуулан өглөө. Энэхүү компьютерийг гардан авсанаар бүлгийн 4 багш нар 100% компьютержиж ажиллах боломж бүрдлээ.



Дани улсын Данида төслөөс зохион байгуулсан “Малчдын 5 настай хүүхдийг гэр бүл түшиглэн сургуульд бэлтгэх нь” сургалтад 2023.08-19-21 ны хооронд 2 багш хамрагдлаа.



СБ аймгийн БШУГ-ын зөвлөн туслах ажлын хэсэг 09 сарын 13ны өдөр суманд ажиллаж цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслалаа.

Байгууллагын сул орон тоонд сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр 15 хоног зарлаж багшийн туслахад -4 иргэн бүртгүүлж сонгон шалгаруулалтанд хамрагдаж 2 иргэн сонгогдож багшийн туслахаар ажиллаж байна.




2. Хүүхэд хөгжил хамгаалал

2023-2024 оны хичээлийн жилд 2 нас-25, 3 нас-30, 4 нас-30, 5 нас-34 нийт өдрийн бүлэгт 119 хүүхэд хувилбар сургалтаар-30 хүүхэд СӨБ-д 149 хүүхдийг хамруулан ажиллаж байна. Мөн хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.



Боловсролын сүлжээний сургалтын үйлчилгээний нил-16, 2-5 настай 149 хүүхдийн мэдээллийг хамруулж бааз

Бүлгийн багш нар, багшийн туслах нар хүүхдийн насны онцлог сургалтын агуулгын дагуу сургалтын хөтөлбөрийг жил, сар болон өдөр тутмын аргачлал, өдрийн дэглэмийг боловсруулан ажилласан.



3. Эрүүл ахуй, хоол хүнс

Эрхлэгч, бүлгийн багш, туслах багш, тогооч, үйлчлэгч нийт 9 албан хаагч урьдчилан сэргийлэг үзлэг-2, шинжилгээ-3 хамрагдсан. Мөн 9 албан хаагч хеликобактерийн шинжилгээнд бүрэн хамрагдлаа. Мөн АНЭ эрт илрүүлэгт -6 албан хаагч хамрагдлаа. Төсөв -549,000 төгрөг зарцуулсан.



Бүлгийн хүүхдүүдийг хүлээн авах бэлтгэл ажлын хүрээнд 4 бүлгийн 110 хүүхдийг цагаан хорхойн шинжилгээнд хамрууллаа.

Хүүхдийн хоолны цэсийг 5 хоногоор гаргаж батлуулан өдөр болгон өдөрлөгөөрөө няраваас хүнсээ авч өдрийн бүлгийн 119 хүүхдэд үйлчилж байна.

Хоолны дээж өдөр бүр авч 72 цагийн дараа жижүүр багшийн хяналтан дор устгал хийж тэмдэглэл хөтөлдөг. Хоолны амталгааг жижүүр багшаар хийлгэж тэмдэглэл хөтөлж хэвшсэн.

Хүний нэр	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
1. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
2. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
3. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
4. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
5. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл



Хүүхдийн хоол хүнс хадгалах склад агуулахыг цэвэрлэн хөргөгч хөлдөөгч хүнсний тавиурыг содын уусмалтай усаар цэвэрлэн ариутгал халдваргүйтгэлийг хийсэн. Их цэвэрлэгээг бүрэн хийж хүүхдийн хоолны материалыг татан авсан.



Ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулж баталгаажуулсан.

Хүний нэр	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
1. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
2. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
3. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
4. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
5. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл

Хүний нэр	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
1. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
2. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
3. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
4. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл
5. Хүүхэд	Төлөв	Хоолны дээж	Хоолны амталгаа	Тэмдэглэл

<https://www.esis.edu.mn/teacher> хаягаар нэвтрэн орж хоолны цэсийг 7 хоног бүрийг 1 дэх өдөр шивж оруулан баталгаажуулж байна. 9 сард 2 долоо хоногийн хоолны цэс шивж оруулсан.



Ангийн бүх тоглоомыг өдөр бүр содын 2% уусмалаар ариутгадаг. Чийгтэй цэвэрлэгээг 0,015% өдөр бүр 2оос Зудaa их цэвэрлэгээг долоо хоногт 2удaa тогтмол хийдэг.



Байгууллагын гадна хог хаягдлыг болон зэрлэгийг хогны машин дээр ачсан. Мөн урд хогийн цэгний гадна тараасан хогийг түүж цэвэрлэж шатаасан.



Жижүүр, үйлчлэгч нар хамтран ОО-ын суултуурын тагыг сольсон. Төсөв 212,000 төгрөг



Байгууллагын жижүүрүүд гадна сүүдрэвчийг гагнаж аюулгүй байдлыг хангаж ажилласан.



4. Бүтээлч ажил


2 настай хүүхдийг шинээр авах бэлтгэл ажлыг хангаж 2 гэрийг засаж сайжруулан барьж тохижилтыг хийсэн. Төсөв-985,000 төгрөг зарцуулсан.



Бүлэг бүр хүүхдийн сандалд бүрээс хийж таних тэмдэгжүүлэн хүүхдийн эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангаж ажилласан.



Байгууллагын хэмжээнд 3 ангид, гал тогоонд, ажилчдын дунд ус цэвэршүүлэх төхөөрөмжийг байршуулж цэвэршүүлсэн ус уух хоол ундандаа ашиглах боломжоор хангагдсан. 2900000 төгрөгний өртөгтэй.



Яамнаас цэцэрлэгийн шинэ барилгын явцтай танилцахаар ажлын хэсэг ирж 1 өдөр ажилласан.



100 хүүхдийн шинэ цэцэрлэгийн барилгын явц 50-55%-тай байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн ажилын хүрээнд

- Нийт үзлэг-936
- Урьдчилан сэргийлэх-257
- Амбулаторт-451
- Идэвхитэй хяналт-46
- Дуудлагаар гэрийн-37
- Гэрийн эргэлт-45

Артерийн гипертензин эрт илрүүлэг-213

Чихрийн шижин эрт илрүүлэг-112

Жирэмсний хяналтанд байгаа-18

- Шинээр хамрагдсан-6

Хөхний үзлэг-78

Эсийн шинжилгээ-16

Эмчилсэн эмэгтэйчүүд-4

Эмнэлэгт хэвтсэн-114

Холын дуудлага-58

Төвийн дуудлага-243

- Дусал тариа- 1012
- Судас тариа-1756
- Булчин тариа-236
- Арьсан доорх тариа-46
- Уян зүү-52
- Боолт-146

Сэргээн засах:

- Хэсэгчилсэн зөөлөн бариа-18
- Утлага-11
- Бумба-13

Лаборатори:

- Шээсний шинжилгээ-79
- В,С вирусын шинжилгээ-112
- ДОХ,Тэмбүү шинжилгээ-16
- Сахар-8
- Covid-24
- Альбумин-36
- Билирубин-16
- Үе мөч-13
- Алат асат-15
- Амилаза-36

Ариутгал

- Нийт үзлэг багаж-74
- Хөвөн бөмбөлөг-54
- Амбу-26
- Дэлгэш-2
- Эмэгтэйчүүдийн багаж-9
- Эмэгтэйчүүдийн толь-12

Дархлаажуулалт

Сургуулийн 7 настай 32 хүүхдийг заавал хмарагдах сахуу татрангын вакцинд хамруулж, зөвөлгөө өгсөн

Сургалт сурталчилгаа

Иргэд рүү чиглэсэн

Зөв хооллолт давсны хэрэглээгээр 18 хүнд сургалт орсон



Хүүхдийн хоолоор 8 эхэд сургалт хийсэн



Вакцинд хамрагдсан эцэг эхчүүдэд “ вакцины ач тус” сэдэвт зөвлөмжийг хүргэсэн.



Хүйтэн сэрүүний улирал эхэлж буйтай холбогдуулан ЕБС-ийн сурагчдад ханиаднаас сэргийлэх сургалтийг 84 сурагчдад зохион байгуулж, 7 ангид зөвлөмж байршуулан ажилласан.



Сумын баяр наадам, сунгаан үсэргээний үеэр унаач хүүхдийн аюулгүй байдал, наршилт осол гэмтлээс сэргийлэх 100ш зөвлөмж зөвлөгөө тараан ажилласан.



Улсын болон сумын баяр наадам аялал зугаалга эхэлж буйтай холбогдуулан гэрийн эргэлтээр 10 ахмад настан 14 бага насны хүүхдэд

- Наршилт
- Үеэр ус
- Осол гэмтэлээс сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг тараан ажилласан.



Хэвтэн эмчлүүлэгчийн ёс зүй дүрэм журмыг хэвтэн эмчлүүлсэн 21 иргэнд танилцуулсан.



Эмч ажилчид руу чиглэсэн.

1. ЭМС-ын 2018 оны А/16 тоот тушаал “Эмчилгээний хоолны удирдамж” сэдвээр 14 эмч, эмнэлгийн ажилчдад сургалт зохион байгуулсан.



- Эрүүл мэндийн газараас “ Гепатитын вирусийн халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ” талаарх сургалтыг зохион байгуулж түүнд лаборант бага эмч нар хамрагдсан



Санхүүгийн тайлан мэдээ

Төсвийн гүйцэтгэлийн 7,8-р сарын маягтын дагуу гаргаж ЭМГ-ын ерөнхий ня-бо руу явуулсан.


Нийгмийн даатгалын 7,8-р сарын тайланг гаргаж байгууллагын даргаар баталгаажуулан нийгмийн даатгалын байцаагчид өгч илгээсэн.

Шилэн дансны цахим сайтад байгууллагын 7,8-р сарын мэдээллийг сар бүр оруулах хэсэгт-3, тухай бүр оруулах хэсэгт-9, хагас жилд оруулах хэсэгт-3, бүтэн жилд оруулах хэсэгт-2 нийт 18 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан байна. Төсөв санхүүтэй холбогдон гарсан эрхийн актуудыг хавсарган мэдээллэсэн.

Нийт мэдээлэл	Хугацаандаа Мэдээлсэн	Хугацаа хоцорч мэдээлсэн	Мэдээлээгүй
175	100	0	75


№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Тайлан оруулах хугацаа	Замнал	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Төлөвлөгөө	7 хоногийн дотор	БАДАМСҮРЭН ЧУЛУУНГЭРЭЛ	+	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Татварын 2-р улирлын тайланг хугацаанд нь хийж илгээсэн. ЭМГ-ын ерөнхий нябод ирсэн бичгийн хуваарийн дагуу байгууллагын 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг тушааж, тооцоо нийлэв.



БУСАД

1. Сумын баяр наадам болохтой холбоотой эрсдлээс сэргийлж нийт 16-жирэмсэн эхчүүдэд утасаар зөвөлгөө өгч, 2 эхийг үзэж зөвөлгөө өгсөн.



2. Сумын баяр наадам болохтой холбоотой 2023.07.09-ны өдөр 55-унаач хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.



3. Сумын баяр наадмаар хүүхдийн аюулгүй байдлыг хангаж 6 насны моридийг дагаж морьноос ойчсон 4 хүүхдэд анхны тусламж үзүүлэн ажилласан.



Шинэлэг ажил

1. “Жойфүл фамили” компаний гүйцэтгэлээр өөрийн төсөв санхүүгээр хүний эрүүл мэнд өвчлөлийг бууруулах зорилгоор гал тогоонд-1 хэвтэн эмчлүүлэгчдийн хэсэгт-1 шүүлтүүртэй ус цэвэршүүлэгчийн төхөөрөмжийг байршууллаа. Албан хаагчид болон хэвтэн эмчлүүлэгч нар цэвэршүүлсэн ус уух бүрэн боломжтой болсон.



2. Гепатитгүй монголчууд төслийн хүрээнд С вирустэй 10 иргэнийг 3 сарын хэрэглээни эмийн эмчилгээнд үнэ төлбөргүй бүрэн хамруулж, эмчилгээг эхлүүлсэн.
3. Түргэн тусламжийн хол, ойрын биксны цүнхийг шороо тоос орхоос сэргийлж гадна талд уут хийсэн.



4. Халдвартай хог хаягдал, энгийн хог хаягдлыг хаях зааварчилгааг гаргаж 14 өрөөнд байршуулсан.



5. 9 сарын 7-нд Архивын өрөөнд санхүүгийн баримт, анхан шатны маягтуудыг он оноор нь ангилан, ялгаж, цэгцэлсэн.



6. 9 сарын 10-нд УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нар сумын ард иргэдтэй уулзалт хийж, хөдөөгийн 1,2-р багийн иргэдтэй уулзалт хийн, тэдний санал бодлыг сонсож ажилласан. Энэ үеэрээ манай байгууллагын үйл ажиллагааг дэмжиж сүүлийн үеийн хүчин чадалтай **LENOVO** маркын нөүтбүүкийг өгсөнийг байгууллагын дарга, жолооч нарын хамтаар очиж хүлээн авсан.



10. Байгууллагын үйл ажиллагааг тог тасарсан үед хэвийн явуулах зорилгоор 6500 Вт-ийн хүчин чадалтай мотор авсан.



СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу албан хаагчдыг Баруун-урт хотноо Аймгийн нэгдсэн эмнэлэгт “эрт илрүүлэг”-т хамрууллаа.

Бүх нийтийн соёлын боловсролын сургагч багшийн сургалтанд хөгжмийн багш, дарга нар хамрагдлаа.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төсвийн хүрээнд өр авлага үүсээгүй. Өөрийн үйл ажиллагааны орлого 680,000 төгрөг орсон.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1. Сар бүрийн эхний 7 хоногийн 5 дахь өдөр “Судар эгшиглэн” төслийн оролцогчдын уулзалт ярилцлага хийхээр төлөвлөсөний дагуу 07-р сарын 07-ний өдөр сумын “Хүүхдийн элч” Ж.Хүрэлчимэг, ЕБС-ийн номын санч Д.Чимгээ нартай хамтран зохион байгууллаа. Төсөлд оролцож ном уншиж, тэмдэглэл хөтөлж байгаа 5 том хүн, 18 сурагч хамрагдсан.

3.2. Номын сангийн фондонд байгаа номыг цахимд оруулах ажлыг эхлүүлээ.

3.3. Номын баяр, эх хэлний өдрийг угтан “Номын ертөнц” шинэ номын үзэсгэлэн танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явууллаа.

3.4.2023-2024 оны хичээлийн жилийн эхний өдөр “Эх хэлний өдөр зарлах тухай” зарлигийн 4-т заасны дагуу 9-р сарын 1-ний өдрийн 1-р цагийг “Эх хэлний үүсэл хөгжил” сэдвээр зохион байгуулж анги удирдсан багш нар, ЕБС-н номын санчтай хамтран удирдан чиглүүлж ажиллалаа. Энэ хичээлийн хүрээнд түүх нийгмийн ухаан болон монгол хэл уран зохиолын багш нар хамтран цахим мэдээлэл бэлтгэн оруулсан ба сурагчдын бүтээл хийлгэж үзэсгэлэн гаргалаа.

3.5. Цахим орчинд эх хэлээрээ бахархах үзлийг төрүүлэх зорилгоор постер бэлтгэж олон нийтийн сүлжээнд түгээлээ.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Аймгийн ахмадын нумт харвааны аварга шалгаруулах тэмцээн 7-р сарын 1,2-ны өдрүүдэд болж өнгөрлөө. 17 багийн 130 гаруй ахмад харваачид цэц мэргэнээ сорьлоо.

4.2. Алтан дарь овооны тэнгэрийг тайх ёслол 110 жилийн ойд ардын авьяастан өндөр настан морин хуурч Х.Дугаржав агсан 100 жилийн түүхтэй хэлхээ тоонотой гэр болон эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйл, мөн биет бус өв тээгч морин хуур урлаач А.Цэрэндорж агсаны бүтээлээр үзэсгэлэн гаргалаа.

4.3. Улаанбаатар хотноо горхи тэрэлжид зохиогдсон “Нүүдэлчин дэлхийн фестивальд” хөгжмийн багш ёочин хөгжмөөр оролцлоо.

4.4. Түүх соёлын дурсгалт газрыг гэрээт хамгаалагчтай байгуулах гэрээг 3хувь үйлдэж засаг даргаар батлууллаа.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. 7-р сарын 1-с эхлэн хөгжмийн дугуйланд нэмэлт элсэлт авч, үкүлэлэ 2, даралтат хөгжим 5, ёочин 3, нийт 10 хүүхэд хамрагдаж байна.Бүжгийн дугуйланд 6-р сарын 20-с эхлэн наадмын бэлтгэлд 24 хүүхэд хамрагдаж 6 бүжиг бүжиглэлээ.

5.2. 9-р сарын 8-с эхлэн **Хөгжмийн дугуйланд** нэмэлт элсэлт авч, үкүлэлэ 8, даралтат хөгжим 11, ёочин 3, гитар 8, мандолин 10 нийт 40 хүүхэд хамрагдаж байна.

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ:

6.1. Ардын хувьсгалын 102 жил, Наран сум үүсэн байгуулагдсаны 68 жилийн ойн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг 07-р сарын 10-ны өдөр 11 цагаас зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 7 ардын авьяастан, 29 хүүхэд оролцлоо. 1 цаг 15 минутын үйл ажиллагааг зохион байгуулсан.

6.2. Ардын авьяастан Бадарчийн Батаагийн анхны бие даасан “Удмын эгшиглэн” тоглолтыг 07-р сарын 10-ны өдрийн 19 цагаас зохион байгуулсан. Үүнд 5 ардын авьяастан оролцож, 65 үзэгч үзэж сонирхлоо.

6.3. 07-р сарын 10-ны 21 цагаас “Эх нутаг минь” хөтөлбөрт үдшийн цэнгүүнийг зохион байгуулахад 60 иргэн оролцлоо. 120,000 төгрөгийн орлого орсон.

6.4. 07-р сарын 12-ны үдэш 20 цагаас Наран сумын ЕБС-ийн 17-р төгсөлтийн хамт олонтой хамтран “Дурсамж” цэнгүүнийг зохион байгууллаа. Орлого 160,000 төгрөг орсон.

6.5.08-р сарын 01-нд Монгол Улсын аварга малчин Ядамжав агсаны үр хүүхэд ах дүү нар нь “Аваргын төгөл” цэцэрлэгт хүрээлэн байгуулж нээлт болон үдшийн цэнгүүнийг хамтран явууллаа.

6.6.“Намрын ногоо өдрүүд-үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээнд хөгжмийн дугуйлангийн хүүхдүүд урлагийн номер үзүүллээ.

6.7. Хичээлийн шинэ жилийн нээлт Сургууль, Цэцэрлэгийн баярын үйл ажиллагааг хамтран зохион байгууллаа.

6.8. 09-р сарын 09-нд Соёл урлагийн ажилтны баярын өдөрт зориулсан “Соёлтой хамт” явуулын үйлчилгээг 1,2 дугаар багийн иргэдэд амжилттай явууллаа. Мөн УИХ-н гишүүн Ж.Батсуурь Н.Ганибал аймгийн хурлын төлөөлөгч Ө.Тайвансанаа нарын иргэдтэй хийсэн уулзалтанд соёлын ажилчид урлагийн номер үзүүллээ.

6.9. 09-р сарын 11-нд СОЁЛ УРЛАГИЙН АЖИЛТНЫ БАЯР-ын цэнгүүн явуулж 98 иргэн оролцлоо.

6.10. 09-р сарын 12-нд Соёл урлагийн ажилтны баяр-ын өдөрт зориулан “Мэргэжил бүхэн сайхан” албан хаагчдын мэргэжил сурталчлах сургалтуудыг амжилттай зохион явууллаа.Мөн ЕБС-н сурагчдын бүжиг зохиосон.

6.11.Сүхбаатар аймгийн соёл урлагийн ажилтны 30 жилийн ойн баярын хурал, сургалт, спортын тэмцээнд бүх ажилчдаа хамрууллаа.

6.12.Хил хамгаалах байгууллагын түүхт 90н жилийн ойг тохиолдуулан МУБ Чойн Дугаржавын нэрэмжит хилийн цэргийн 0184 дүгээр ангийн хилчин уран бүтээлчид анги байгууллагаа сурталчлах урлаг соёлын арга хэмжээ 09 дүгээр сарын 18 ны өдөр зохион байгуулагдлаа.

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

7.1. 06-р сарын 29-ний өдөр РС mall-ийн цахилгаан барааны лизингийн худалдаа Соёлын төвд 1 өдөр ажиллаа. Байрны түрээсэнд 50,000 төгрөг авлаа.

7.2. Соёлын ажилчдын баярын спортын тэмцээнийг угтан байгууллагадаа волейволын өмсгөлтэй боллоо.

Зүрэг 1.4



Зүрэг 1.5



Зүрэг 3.3



Зүрэг 3.4



Зүрэг 4.1.



Зүрэг 4.2



Зүрэг 4.3



Зурар 4.4



Зурар 6.1.



Зурар 6.8





Зураг 6.11.



Зураг 6.12

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.ЗУЛЦЭЦЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ О.ТУНГАЛАГ